



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.07.21 № 08/66 ЧАТ-САТ/2013/94/СТА-ТЭС

Улсын төсвийн орлого болгох тухай.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараахь зөрчил илэрлээ.

Сонгуулийн ерөнхий хороо нь 2012 онд Увс аймгийн Сонгуулийн хорооны аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг тайлант онд багтаан Сангийн сайдын 2012 оны 295 тоот тушаалын дагуу татан төвлөрүүлээгүйгээс 5,8 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т "Төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй зөрчилд төрийн аудитын байгууллага акт тавина" гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн сонгуулийн зардлын үлдэгдэл 5,8 сая төгрөгийг улсын төсвийн орлого болгож, Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Дээрх төлбөрийг төвлөрүүлж төлбөрийн актын биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сонгуулийн ерөнхий хорооны менежер Д.Баяндүүрэн, ерөнхий нягтлан бодогч Д.Жанчивдорж нарт хариуцуулав.

АКТЫГ

